| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 300,000.00            | 300,000.00            | 0.00                | 100.0       |
| 2109   | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 6234100.00            | 6224380.00            | 9,720.00            | 99.8        |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 2,000,000.00          | 2,000,000.00          | 0.00                | 100.0       |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 4,234,100.00          | 4,224,380.00          | 9,720.00            | 99.8        |
| 213    | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 128000.00             | 128000.00             | 0.00                | 100.0       |
| 2132   | Бусад урсгал шилжүүлэг   | 128,000.00            | 128,000.00            | 0.00                | 100.0       |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 128,000.00            | 128,000.00            | 0.00                | 100.0       |
|        | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | <b>352,641,200.00</b> | <b>348,366,794.60</b> | <b>4,274,405.40</b> | <b>98.8</b> |
| 1310   | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                       | <b>309,477,600.00</b> | <b>305,481,850.24</b> | <b>3,995,749.76</b> | <b>98.7</b> |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих                             | 309,477,600.00        | 305,481,850.24        | 3,995,749.76        | 98.7        |
| 1320   | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                | <b>43,163,600.00</b>  | <b>42,884,944.36</b>  | <b>278,655.64</b>   | <b>99.4</b> |
| 132001 | Орон нутгийн төсвөөс   | 43,163,600.00         | 42,884,944.36         | 278,655.64          | 99.4        |
| 62     | <b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>   | <b>19</b>             | <b>19</b>             | <b>00</b>           | <b>100</b>  |
| 620001 | Удирдах ажилтан  | 01                    | 01                    | 00                  | 100         |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан  | 11                    | 11                    | 00                  | 100         |
| 620003 | Үйлчлэх ажилтан  | 07                    | 07                    | 00                  | 100         |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага   | 170                   | 155                   | 15                  | 91          |

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

|             |  |          | / төгрөгөөр /        |
|-------------|--|----------|----------------------|
| Дансны код  | Үзүүлэлт   | Өмнөх он | Гүйцэтгэл            |
|             | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>  |          |                      |
| <b>I</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>   |          | <b>21,402,812.00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   |          | <b>21,402,812.00</b> |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | 0.00     | 21,402,802.00        |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  |          | 21,402,802.00        |
| 213207      | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж  |          | 16,816,612.00        |
| 213208      | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг                      |          | 4,586,200.00         |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>  | 0.00     | 21,402,812.00        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   |          | 21,402,812.00        |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө |          | 21,402,812.00        |
| <b>IV</b>   | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>  |          |                      |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл   |          |                      |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл  |          |                      |

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч С.Шүрэнцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 19-нөөс 2021 оны 02 дугаар сарын 25-ний хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэг нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 69 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Багшийн хөгжлийг дэмжсэнээр хүүхдэд эерэг зан чанар, хандлагыг төлөвшүүлэн, тэдний мэдлэг эзэмших чадварыг хөгжүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн

баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 245943,8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 4918,9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 387448,0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7748,9 мянган төгрөгөөр тооцов.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 571463,3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 8343,9 мянган төгрөгөөр буюу 1,4 хувиар буурсан нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, Засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

| төгрөг/ | Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт  |
|---------|---|----------------|-----------------|-----------|
|         | Б   | 1              | 2               | 3=2-1     |
|         | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>                    | 53,947.3       | 45,511.3        | (8,436.1) |
|         | Мөнгөн хөрөнгө                                    | -              | -               | -         |
|         | Авлага  | 233.1          | 197.1           | (36.0)    |
|         | Урьдчилгаа  | -              | -               | -         |
|         | Бараа материал                                    | 53,714.2       | 45,314.1        | (8,400.1) |
|         | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                | 525,860.0      | 525,952.1       | 92.1      |
|         | Үндсэн хөрөнгө                                    | 578,642.5      | 587,992.3       | 9,349.8   |
|         | Хуримтлагдсан элэгдэл                             | (52,782.5)     | (62,040.2)      | (9,257.7) |
|         | <b>Нийт хөрөнгө</b>                               | 579,807.3      | 571,463.4       | (8,343.9) |
|         | Өр төлбөр   | 378.4          | -               | (378.4)   |
|         | Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 579,428.9      | 571,463.4       | (7,965.5) |
|         | <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | 579,807.3      | 571,463.4       | (8,343.9) |

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Өмнөх оны авлагыг бүрэн барагдуулсан боловч 197,1 мянган төгрөгийн авлага шинээр үүссэн нь 100,0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа суутган тооцоогүй 97,1 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг илүү шилжүүлснээс үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 45314,1 мянган төгрөг болж 8400,0 мянган төгрөгөөр буурсан аж ахуй материал, хүнсний материалын өмнөх оны үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 587992,2 мянган төгрөг болж 9349,8 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан 5248,5 мянга, төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 4526,3 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 5248,5 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 2239,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 2287,3 мянган төгрөгөөр тавилга эд хогшил худалдаж авсан хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2020.11.06 ний өдрийн 108 дугаар тогтоолоор ашиглалтгүй байсан 425,0 мянган төгрөгийн программ хангамжийг данснаас хассан байна.

Өмнөх онд ажиллагсадтай холбоотой үүссэн 378,4 мянган төгрөгийн богино хугацаат өр төлбөрийг бүрэн барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 571463,3 мянган төгрөг болж 7965,5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 5965,5 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 379482,5 мянган төгрөг болж, өмнөх оноос 51155,0 мянган төгрөгөөр буюу 15,5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсөвт байгууллагын өөрийн орлого, тусламж санхүүжилтийн орлого байна. Төсөвт байгууллагын өөрийн орлого өмнөх оноос 3188,5 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээж авсан орлого өмнөх оноос нэмэгдсэнтэй, тусламж санхүүжилтийн орлого 20758,1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 27208,1 мянган төгрөгөөр нэмэгдэж, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 2607,1 мянган төгрөгөөр өссөн, нэмэлт санхүүжилтийн орлого 18151,0 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал 387448,0 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 69302,1 мянган төгрөгөөр буюу 21,7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, хангамж бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зарлагыг 339986,0 мянган төгрөгөөр, хүүхдийн тоог 160 ажиллагсдын тоог 22 орон тоогоор тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 55542,2 мянган төгрөгөөр бууруулж 395528,2 мянган төгрөг, хүүхдийн тоог 170 ажиллагсдын тоог 19 орон тоогоор баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 39552862 мянган төсөв батлагдаж 3 удаа тодотгол хийн 352641,2 мянган төгрөгийн төсөв баталснаас 309477,6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр 43163,6 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 43163,6 мянга, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 309477,6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 348366,7 мянган төгрөгийг зарцуулж 4324,4 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 348366,7 мянган төгрөг буюу 98,7 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 407,8 байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 278,6 мянга, эд хогшил худалдан авах 3363,7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээний 4274,4 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

| Үзүүлэлт  | Төлөвлөгөө     | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү        | Хувь   |
|---|----------------|-------------------|--------------|--------|
| ХӨТӨЛБӨР 71801 Сургуулийн өмнөх боловсрол                 | 352,641,200.00 | 348,366,794.60    | 4,274,405.40 | 98.8   |
| <b>АРГА ХЭМЖЭЭ 80109 ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал</b> |                |                   |              |        |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                         | 43,163,600.00  | 42,884,944.36     | 278,655.64   | 99.4   |
| УРСГАЛ ЗАРДАЛ   | 43,163,600.00  | 42,884,944.36     | 278,655.64   | 99.4   |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                           | 43,163,600.00  | 42,884,944.36     | 278,655.64   | 99.4   |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                 | 38,163,600.00  | 37,884,944.36     | 278,655.64   | 99.3   |
| Урсгал засвар   | 5,000,000.00   | 5,000,000.00      | -            | 100.0  |
| <b>АРГА ХЭМЖЭЭ 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,</b>    |                |                   |              |        |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                         | 128,000.00     | 128,000.00        | -            | 100.0  |
| УРСГАЛ ЗАРДАЛ   | 128,000.00     | 128,000.00        | -            | 100.0  |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ  | 128,000.00     | 128,000.00        | -            | 100.0  |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал                           | 128,000.00     | 128,000.00        | -            | 100.0  |
| <b>АРГА ХЭМЖЭЭ 81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол</b>        |                |                   |              |        |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                         | 23,313,900.00  | 23,303,177.00     | 10,723.00    | 100.0  |
| Норматив зардал   | 23,313,900.00  | 23,303,177.00     | 10,723.00    | 100.0  |
| <b>АРГА ХЭМЖЭЭ 81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа</b>   |                |                   |              |        |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                         | 21,972,700.00  | 17,987,700.00     | 3,985,000.00 | 81.9   |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил                        | 14,639,100.00  | 14,639,100.00     | -            | 100.0  |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл            | 1,829,900.00   | 1,829,900.00      | -            | 100.0  |
| Хангамж бараа материалын зардал                           | 1,656,500.00   | 1,518,700.00      | 137,800.00   | 91.7   |
| эд хогшил авах зардал                                     | 3,847,200.00   |                   | 3,847,200.00 | 0.0    |
| <b>АРГА ХЭМЖЭЭ 81834 Боловсролын стандарт, сургалтын</b>  |                |                   |              |        |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                         | 264,063,000.00 | 264,062,973.24    | 26.76        | 100.00 |
| УРСГАЛ ЗАРДАЛ   | 264,063,000.00 | 264,062,973.24    | 26.76        | 100.00 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                           | 264,063,000.00 | 264,062,973.24    | 26.76        | 100.00 |

**Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

|  |                |                |             |        |
|--|----------------|----------------|-------------|--------|
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил             | 218,493,500.00 | 218,485,659.24 | 7,840.76    | 100.00 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 27,861,700.00  | 27,861,700.00  | -           | 100.00 |
| Хангамж бараа материалын зардал                | 3,477,100.00   | 3,516,933.00   | (39,833.00) | 101.15 |
| Норматив зардал                                | 4,790,600.00   | 4,777,100.00   | 13,500.00   | 99.72  |
| Эд хогшил авах зардал                          | 1,000,000.00   | 1,000,000.00   | -           | 100.00 |
| Урсгал засвар                                  | 1,196,300.00   | 1,195,501.00   | 799.00      | 99.93  |
| Томилолт зочны зардал                          | 119,500.00     | 112,000.00     | 7,500.00    | 93.72  |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр | 890,200.00     | 889,700.00     | 500.00      | 99.94  |
| Бараа үйлчилгээний бусад зардал                | 6,234,100.00   | 6,224,380.00   | 9,720.00    | 99.84  |

Эх сурвалж: Байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт:**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс 21452.8 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилсан.

Үүнээс Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 4586.2 мянга, тэтгэвэрт гарахад нь олгох тэтгэмжийн зардал 16816.6 мянган төгрөгийг зарцуулж 50.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

**3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуулийн дагуу байршуулбал зохих 151 мэдээллээс 128 мэдээллийг байршуулсан. Үүнээс хугацаа хоцорсон 21 мэдээлэл байна.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 119452,4 мянган төгрөгийн гүйлгээг хоцроож мэдээлсэн байна.

| д/д | Хугацаа    | Төрөл | Удаа | Хугацаанд байршуулсан | Хугацаа хоцроож байршуулсан | Байршуулаагүй | Хугацаа болоогүй |
|-----|------------|-------|------|-----------------------|-----------------------------|---------------|------------------|
| 1   | Бүтэн жил  | 11    | 11   | 7                     | 2                           | 0             | 2                |
| 2   | Хагас жил  | 4     | 4    | 4                     |                             |               |                  |
| 3   | Улирал бүр | 1     | 4    | 4                     |                             |               |                  |
| 4   | Сар бүр    | 3     | 36   | 29                    | 7                           |               |                  |
| 5   | Тухай бүр  | 8     | 96   | 84                    | 12                          |               |                  |
|     | Нийт       | 27    | 151  | 128                   | 21                          | 0             | 2                |

Эх сурвалж: Байгууллагын шилэн дансны цахим сангаас

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2543,3 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосныг барагдуулж, зөрчлийг арилгах 2 албан шаардлыг өгснийг биелэлтийг 2020.06.15 ний өдрийн 36 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

*Хүснэгт 4.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

| Үзүүлэлт        | Өмнөх оны илрүүлэлт |        | Биелэлт |        | Зөрүү |     |      |
|-----------------|---------------------|--------|---------|--------|-------|-----|------|
|                 | Тоо                 | Дүн    | Тоо     | Дүн    | Тоо   | Дүн | Хувь |
| Акт             | 2                   | 2543.3 | 2       | 2543.3 |       |     |      |
| Албан шаардлага | 2                   | -      | 2       |        |       |     |      |
| Нийт дүн        | 4                   | 2543.3 | 4       | 2543.3 |       |     |      |

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1500,0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 акт тогтоож алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө. /Хавсралт 1/

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай илэрхийлэгдсэн зардал байхгүй

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 1500,0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч 1500,0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлээ. Үүнд:

Тухай байгууллагад халаалтын үйлчилгээ үзүүлдэг “Зүүн шанд” ХХК-д 8 дугаар сард өмнөх оны халаалтын зардлын зөрүүд 1500.0 мянган төгрөгийг өмнөх онд өглөг үүсээгүй байхад шилжүүлж төсөв хэтрүүлж зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг зөрсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоож буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр шийдвэрлэв.

#### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 2 зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаар татсан асуудал байхгүй

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 1. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2020 онд нийт 151 мэдээллээс төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, хөрөнгийн урсгал зардалд орсон өөрчлөлт, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 79942,5 мянга, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 39509,9 мянган төгрөгийн 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн.

1.1 Эрсдэл: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх.

1.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээллүүдээс төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, өөрчлөлт, хөрөнгө урсгал зардал, орон тоонд орсон өөрчлөлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын хугацаа хоцроож мэдээлсэн зөрчлийг арилган, цаашид хуулийг хэрэгжүүлж ажиллах.

1.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

##### 2. Балансын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт. Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 10360.5 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглагдах жилийг санхүүгийн программд оруулаагүйгээс тайлант онд элэгдэл байгуулаагүй байна.

2.2 Эрсдэл: Үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулаагүй байх.

2.2 Өгсөн зөвлөмж. Үндсэн хөрөнгийн ашиглагдах жилийг зөв бүртгэж, тайлант жилийн элэгдлийн зардлыг зөв илэрхийлж байх

2.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:  
АУДИТОР

Н.БҮНЧИНСҮРЭН 2021.02.25

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:  
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ 2021.02.25

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:  
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ 2021.02.25

### 5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо                        | Аудитын нэр:   | Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | Аудитын код:                          |   |                             |
|------------------------------|--|---|---------------------------------------|---|-----------------------------|
| 2020                         |  |   | БНА-2021/56/СТА-ТШЗ                   |   |                             |
| Шалгагдсан байгууллагын нэр: |  | Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэг  | Мянган төгрөг                         |   |                             |
| №                            | Алдаа, зөрчлийн товч утга  | Мөнгөн дүн  | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны |                             |
|                              |  |   |                                       | Албан тушаал                                      | Овог нэр                    |
| 1                            | 2  | 3   | 4                                     | 5   |                             |
| 1                            | Тухай байгууллагад халаалтын үйлчилгээ үзүүлдэг "Зүүн шанд" ХХК-д 8 дугаар сард өмнөх оны халаалтын зардлын зөрүүд 1500,0 мянган төгрөгийг өмнөх онд өглөг үүсээгүй байхад шилжүүлж төсөв хэтрүүлж зарцуулсан.   | 1500.0  | Төлбөрийн акт тогтоох                 | Эрхлэгч, нягтлан бодогч                           | С.Шүрэнцэцэг, Б.Бүрэнжаргал |
| 2                            | Шилэн дансны тухай хуулийн дагуу байршуулбал зохих 151 мэдээллээс 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. Үүнээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 119452,4 мянган төгрөгийн гүйлгээг хугацаанд нь мэдээлээгүй байна | 0   | Зөвлөмж өгөх                          | Эрхлэгч, нягтлан бодогч                           | С.Шүрэнцэцэг, Б.Бүрэнжаргал |
| 3                            | Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 10360.5 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглагдах жилийг санхүүгийн программд оруулаагүйгээс тайлант онд элэгдэл байгуулаагүй байна.  | 10360.5   | Зөвлөмж өгөх                          | Эрхлэгч, нягтлан бодогч                           | С.Шүрэнцэцэг, Б.Бүрэнжаргал |
| ДҮН                          |  | 11860.5   |                                       |   |                             |

оОо